



ЦАГААН ШОНХОР ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.АРИУНЗАЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 02.20 № 3/225
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газраас аудит хийв.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, СТОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн аудитын газар аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 С.ЭНХЗАЯА



ЦАГААН ШОНХОР ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 261885
Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512
Цахим хаяг: Batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг:
Үндэсний аудитын газар
Байршил: Засгийн газрын IY байр,
Бага тойруу 6, Улаанбаатар-46
Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Баян Сагсай Аудит” ХХК
Утас: 99090188
Цахим хуудас: www.bsaudit.mn
Цахим хаяг: munkhtsetseg@bsaudit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ/2017/75/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 16-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-тай 48 дугаар гэрээ байгуулсны үндсэн дээр “Баян Сагсай Аудит” ХХК – ийн аудиторуд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд 1/17 дугаар бүхий албан тоотын хамт Баян Сагсай Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд Цагаан шонхор ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын захирал нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг

тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Төрийн өмчийн хуулийн этгээдтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 33-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Цагаан шонхор ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цагаан шонхор ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт дунд байна.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагааны нийт орлого 960.4 сая төгрөг, өртөг, үйл ажиллагааны болон бусад зардалд 929.8 сая төгрөг зарцуулж, 27.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж shilendans.gov.mn веб сайт дээр цалин хөлснөөс бусад 5.0 сая төгрөгнөөс дээш төрийн сангаас хийгдсэн бүх гүйлгээг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, борлуулалтын орлого, цалин хөлсний тооцоо, засвар үйлчилгээ, шуудан холбооны зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

Үүнд:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүн болон бусад мөнгөн орлого болох нийт 26.8 сая төгрөгөөр борлуулалтын орлогыг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн, зөв байх зарчмыг баримтална” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Борлуулалтын орлогын дүнг 26.8 сая төгрөгөөр, цалингийн зардлыг 1.9 сая төгрөгөөр тус тус бууруулах, НДШ-ийн өглөгийг 1.5 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашгийг 23.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх залруулах бичилт хийлгэв.

2. Татварын өглөгийн талаар

- ХХОАТ-ийн өглөгийг 5.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн, зөв байх зарчмыг баримтална” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: ХХОАТ-ын өглөгийг 5.1 сая төгрөгөөр бууруулах, хуримтлагдсан ашгийг 5.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулах бичилт хийлгэв.

- Бусад татварын өглөгийг 0.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Бусад татварын өглөг, бусад татварын зардлыг 0.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх залруулах бичилт хийлгэв.

3. НББББ-ийн талаар

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасан “ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

- Дансны төлөвлөгөөгөөр данс буруу кодлогдсон байгаа нь Сангийн Сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 тоот тушаалын 2 дугаар хавсралтын 2.2-д “ Улсын хэмжээнд дансны жагсаалтын эхний хоёр орон нэг ижил кодтой байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар Сангийн Сайдын 249 дүгээр журмыг хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. Үйлдвэрлэлд гарсан зардлыг шууд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэсэн ангиллаар зүй зохистой хуваариалан, “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тайлан”-г гаргадаггүй. Энэ нь бүтээгдэхүүний нэгжийн өөрийн өртгийг тодорхойлж чадахгүйд хүрэх ба бүтээгдэхүүн тус бүрээс олох нэгжийн ашиг тодорхой бус байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжийн өртгийг зүй зохистой тодорхойлж чадахгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.5.хэмжигдэхүйц байх;” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар өөрийн онцлогт тохирсон зардлын бүртгэлийн оновчтой аргыг сонгон хэрэглэх талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

5. Худалдан авах ажиллагааг батлагдсан маягт аргачлалын дагуу төлөвлөж тайлагнаагүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “ Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “ Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” -ыг мөрдөж ажиллах талаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад орлого нэмэгдүүлэх бичилт хийсэн 26.8 сая төгрөг, бусад татварын өглөг болон бусад татварын зардлыг дутуу бүртгэсэн 0.9 сая төгрөг, ХХОАТ-ийг илүү тайлагнасан нийт 5.1 сая төгрөг, нийт 32.8 сая төгрөгийн алдааг залруулсан. Залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна:

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4 төрлийн зөрчил илэрсэн. Үүнд: НББ-ийн бодлогын баримт бичиггүй, Сангийн Сайдын 249 тоот тушаалын дагуу дансаа кодлоогүй, үйлдвэрлэлийн зардалын бүртгэлийн оновчтой арга хэрэглээгүй, худалдан авах ажиллагааг батлагдсан маягт аргачлалын дагуу төлөвлөж тайлагнаагүй.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний Аудитын Газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд нэг зөвлөмжийг нь бүрэн хэрэгжүүлж, үлдсэн 2-ыг нь хагас хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн тайлан, тодруулга 11 хуудас тус тус хавсаргав.



ЦАГААН ШОНХОР ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Борлуулалтын орлогын талаар..... 11

Асуудал 2
Татварын өглөгийн талаар..... 12

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
НБББББ-ийн талаар.....13

Асуудал 2
Үйлдвэрлэлийн өртөг, зардлын талаар14

Асуудал 3
Худалдан авах ажиллагааны талаар15

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Цагаан шонхор ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цагаан шонхор ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Борлуулалтын орлого	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүн болон бусад мөнгөн орлого болох нийт 26.8 сая төгрөгөөр борлуулалтын орлогыг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн, зөв байх зарчмыг баримтална” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Борлуулалтын орлогын дүнг 26.8 сая төгрөгөөр, цалингийн зардлыг 1.9 сая төгрөгөөр тус тус бууруулах, НДШ-ийн өглөгийг 5.1 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашгийг 23.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх залруулах бичилт хийх, цаашид алдаа гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх.

Эрсдэлүүд

Байгууллагын ашигт ажиллагаа буруу тодорхойлогдох, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Татварын өглөг	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

ХХОАТ-ийн өглөг 5.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн, зөв байх зарчмыг баримтална” гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад татварын өглөгийг 0.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө “ гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

ХХОАТ-ын өглөгийг 5.1 сая төгрөгөөр бууруулах, хуримтлагдсан ашгийг 5.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулах бичилт хийх, цаашид алдаа гарахгүй байх талаар зөвлөмж өгөх.

Бусад татварын өглөг, бусад татварын зардлыг 0.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх залруулах бичилт хийх, цаашид алдаа гарахгүй байх талаар зөвлөмж өгөх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, татварыг илүү, дутуу төлөх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: НБББББ-ийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Дансны төлөвлөгөөгөөр данс буруу кодлогдсон байгаа нь Сангийн Сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 тоот тушаалын 2 дугаар хавсралтын 2.2-д заасан “ Улсын хэмжээнд дансны жагсаалтын эхний хоёр орон нэг ижил кодтой байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан бэлтгэгдэж, илэрхийлэгдэхгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх

Сангийн Сайдын 249 дүгээр журмыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Үйлдвэрлэлийн өртөг, зардлын бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Үйлдвэрлэлд гарсан зардлыг шууд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэсэн ангиллаар зүй зохистой хуваарилан, “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн тайлан”-г гаргадаггүй. Энэ нь бүтээгдэхүүний нэгжийн өөрийн өртгийг тодорхойлж чадахгүйд хүрэх ба бүтээгдэхүүн тус бүрээс олох нэгжийн ашиг тодорхой бус байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжийн өртгийг зүй зохистой тодорхойлж чадахгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.5.хэмжигдэхүйц байх;” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Байгууллагын ашигт ажиллагаа буруу тодорхойлогдох, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Өөрийн онцлогт тохирсон зардлын бүртгэлийн оновчтой аргыг сонгон хэрэглэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Худалдан авах ажиллагааны талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Худалдан авах ажиллагааг батлагдсан маягт аргачлалын дагуу төлөвлөж тайлагнаагүй байгаа нь Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-тай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн Сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах үүрэг чиглэл өгөх.

Эрсдэлүүд

Мөнгөн хөрөнгийг дур мэдэн үр ашиг багатай захиран зарцуулах, хөрөнгийн ашиглал шамшигдал үүсэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

2016 оны 12 сарын 31-ээрх

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2015 он	2016 он
	төгрөг	төгрөг
1. ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	43,409,157.42	271,114.06
Дансны авлага		
Бараа материал	6,782,106.00	41,862,482.84
Эргэлтийн хөрөнгийн дүн	50,191,263.42	42,133,596.90
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	97,376,918.21	169,895,205.54
Биет бус хөрөнгө	333,652.27	592,152.27
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	97,710,570.48	170,487,357.81
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	147,901,833.90	212,620,954.71
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өр	28,651,805.00	69,981,805.00
Цалингийн өр		
Татварын өр	14,749,600.00	11,132,235.81
НДШ-ийн өр		
Богино хугацаат зээл		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	43,401,405.00	81,114,040.81
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	43,401,405.00	81,114,040.81
Нийт өр төлбөрийн дүн	43,401,405.00	81,114,040.81
2.2 Эзэмшигчдийн өмч		
Төрийн өмч	87,469,098.00	59,469,098.00
Дахин үнэлгээний нэмэгдэл		
Эздийн өмчийн бусад хэсэг	17,031,330.90	72,037,815.90
Хуримтлагдсан ашиг, алдагдал		
Эзэмшигчдийн өмчийн дүн	104,500,428.90	131,506,913.90
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	147,901,833.90	212,620,954.71

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2016 оны 12 сарын 31

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	2016 он
	төгрөг	төгрөг
Борлуулалтын цэвэр орлого	367,103,159.57	960,456,639.67
Борлуулалтын өртөг	123,917,416.28	463,553,172.58
Нийт ашиг, алдагдал	243,185,743.29	496,903,467.09
Хүүний орлого		
Бусад орлого		
Ерөнхий удирдлагын зардал	213,817,753.23	464,226,412.83
Санхүүгийн зардал		
Бусад зардал	944,304.34	2,076,011.22
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	28,423,685.72	30,601,043.04
Орлогын албан татварын зардал	2,842,368.57	3,060,104.30
Татварын дараах ашиг, алдагдал	25,581,317.15	27,540,938.74
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг, алдагдал		
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	25,581,317.15	27,540,938.74

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2016 оны 12 сарын 31-нээрх

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2014оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	59,469,098.00		(8,549,986.25)	50,919,111.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	59,469,098.00		(8,549,986.25)	50,919,111.75
Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)			25,581,317.15	25,581,317.15
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гаргасан өөрчлөлт		28,000,000.00		28,000,000.00
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2015оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	59,469,098.00	28,000,000.00	17,031,330.90	104,500,428.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл			27,465,546.30	27,465,546.30
Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)			44,496,877.20	131,965,975.20
Бусад дэлгэрэнгүй орлого			27,540,938.74	27,540,938.74
Өмчид гаргасан өөрчлөлт		(28,000,000.00)		(28,000,000.00)
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2016оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	59,469,098.00		72,037,815.90	131,506,913.90

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

2016 оны 12 сарын 31-нээрх

	2015 он төгрөг	2016 он төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	367,093,259.28	958,129,998.54
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	352,186,690.00	953,477,706.96
Даатгалын нөхөн олговор		3,462,004.00
Татаас санхүүжилтын орлого		
Бусад мөнгөн орлого	14,906,569.28	1,190,287.58
Мөнгөн зарлагын дүн	292,607,182.41	944,892,201.90
Ажиллагсдад төлсөн	118,242,561.00	267,356,372.18
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	25,475,308.24	64,249,802.75
Бараа материал худалдан авахад төлсөн	74,996,050.00	508,196,775.00
Ашиглалтын зардалд төлсөн	6,235,544.74	9,479,127.30
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл төлсөн	2,170,550.00	4,161,630.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	8,151,440.44	30,400,020.00
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	57,335,727.99	61,048,474.67
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	74,486,076.87	13,237,796.64
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	-	
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүгийн орлого		
Мөнгөн зарлагын дүн	(31,609,380.00)	56,375,840.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(31,609,380.00)	56,375,840.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	31,609,380.00	(56,375,840.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	5,200,000.00	1,620,000.00
Зээл авсан, үнэт цаас худалдсан	5,200,000.00	1,620,000.00
Мөнгөн зарлагын дүн	(5,200,000.00)	(1,620,000.00)
Зээл, үнэт цаасны төлбөр	(5,200,000.00)	(1,620,000.00)
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,877,695.87	(43,138,043.36)
Мөнгөний эхний үлдэгдэл	531,461.55	43,409,157.42
Мөнгөний эцсийн үлдэгдэл	43,409,157.42	271,114.06